




Оксфордын  
уншлагын  
мод

# Киппер ба Аварга биетэн



Родерик Хант  
Алекс Бричта





Киппер телевиз үзэж байлаа. Тэр “Ууртай аварга хүн” гэдэг хөтөлбөрийг үзэх дуртай.



Үуртай аварга хүн тосгоны ойролцоох шилтгээнд амьдардаг ба тосгоны хэн ч түүнд дургүй. Тэр үргэлжид ууртай байдаг байж.



Аварга хүнийг уурлан алхаж байхад түүний хөлийн чимээгээр байшингууд доргидог байжээ.  
- Өө, үгүй ээ. Тэр дахиад л уурлаж байна. Тэр үргэлж л уурлаж байх юм гэж бүгд ярьдаг байв.



Киппер Чипийг хайсан боловч тэр гадагшаа гарсан байлаа. Тэр шидээт түлхүүрийг авахад түлхүүр туяарч эхлэв. Киппер:  
- Хөөх гэв.




Тэр Биф үрүү гүйсэн боловч тэр мөн Чиптэй хамт гарсан байлаа. Ид шид ажиллаж эхлэв.


Ид шид Кипперийг шидэт байшинд оруулчихлаа.



Ид шид түүнийг аварга хүний шилтгээний өмнөх хаалганд хүргэв. Тэр үед аварга хүн баярт явсан, эзгүй байсан ч Киппер айж байв.



Тэр замын тэмдгийг харлаа.  
Киппер аварга хүнтэй дайралдахыг хүсээгүй  
боловхоор тосгон уруу явлаа.



Киппер маш жижигхэн тосгонд иржээ.  
Киппер тэнд аварга хүн нь байв.  
- Өө, үгүй ээ гэж Киппер гайхжээ.



- Яв, зайл! гэж хүмүүс түүн үрүү хашгиралдаж байв.
- Бид нар чамайг харахыг ч хүсэхгүй байна, бидэнд аварга хүн байгаа, дахиад хэрэггүй гэц-тээж байлаа.



Тэд нар Киппер лүү юм шидэж,  
- Яв, бидэнд дахиад нэг аварга хүн хэрэггүй, бид  
хүсэхгүй байна гэж шуугилдав.




- Больцгоо! Би бол аварга хүн биш, би бол хүү гэхэд хүмүүс,
- Тийм ээ, гэхдээ чи аварга хүн шиг байна гэв.



Киппер уйлж эхлэв.


- Би бол аварга хүн биш, би бол жижигхэн хүүхэд.  
Би энэ адал явдлыг хүсэхгүй байна гэв.



- Аварга хүн минь битгий уйл. Магадгүй тэд бидний дэргэд л аварга харагдаж байгаа боловч хүүхэд байх. Тэр бидэнд тусалж ч магад гэж хүмүүс хэлэлцэв.



Киппер тосгоныхонд тэдний эвдэрсэн байшин, дээврийг сольж янзлахад тусалжээ. Хүн бүр “Сайн, том Киппер” гэцгээж байв.



- Аварга хүн бидэн үрүү энэ том чулууг шидсэн. Бид үүнийг энд байлгахыг хүсэхгүй байна. Чи үүнийг тосгоноос гаргаж чадах уу? гэж хүмүүс асуув.



Киппер:

- Тиймээ, би үзээд алдъя гээд тэр чулууг тосгоноос гаргаж хаяв. Бүгд л “Сайн, том Киппер” гэцгээж байв.



Бүх хүн түүнд хайртай болж,  
- Баярлалаа, чи бидэнд маш их туслалаа гэцгээв.  
Тосгоны хамтлаг ч түүнд зориулж хөгжим тоглож  
өгөв.



Аварга хүн буцаж ирэн, Кипперийг тосгонд  
байхыг хараад маш их уурлав.



- Би эндэхийн аварга хүн байна гэж тэр хашгирав. Тэр тосгоныг зүглэж гүйсэн боловч чулуунд тээглэж ойчлоо. Тэр:  
- Ёoox! гэж дуу алдлаа.



Хүмүүс аиж байсан боловч Киппер түүнд туслахаар очив. Тэр түүний номнуудыг цуглувулаад, толгойг нь ороож өглөө.



Харин Киппер тэр аварга хүнээс том байв.  
Тэгээд:

- Одоо чи сайн аварга хүн бол! Хэрвээ уурлаж бухимдахаа боливол хүмүүс чамд сайн байх болно гэв.



Тэгээд аварга хүн уурлаж бухимдахаа болив.

- Би сайн байхыг хичээнэ ээ гэж тэр хэллээ.

Хүмүүс “Ура” хашгирч,

- Бүгдээрээ үдэшлэг хийцгээе! гэв.



Түлхүүр туяарч эхэллээ.

- Одоо миний явах цаг боллоо. Баярлалаа, та бүгдийн үдэшлэгт гэж Киппер хэлэв.



Ид шид Кипперийг гэрт нь авчирлаа.

- Бүгд ууртай аварга хүнд дургүй. Ямар сайхан адал явдал вэ! гэж Киппер хэллээ.





Оксфордын  
уншлагын  
мод

Шатлал 6  
Түүхүүд

# Киппер ба Аварга биецэн

Киппер аварга биетэнтэй уулзахыг  
хүсч байна. Гэхдээ үлэмж  
биетэн гэж хэн бэ?



Хэвлэн нийтлэлийг  
Интерпресс XXX



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.